

“Их цааз”-ын эх бичгийн судалгааны зарим асуудал

Б.Батбаяр (МУИС)

Өнгөрсөн хоёр зуу орчим жилийн хугацаанд Монголын судлалаар нэлээдгүй бүтээл туурвил гарсан бөгөөд тэдгээрийн тодорхой хувь нь эх бичгийн судлалд холбогдож байна.

Монголын судлалд хууль цаазын түүхэн эх сурвалжийг эх бичиг судлалын хүрээнд тусгайлан дагнан туурвисан бүтээл ховор болно.

Ер нь Оросын эрдэмтэн К.Ф.Голстунский, С.Д.Дыльков, БНХАУ-ын ӨМӨЗО-ы эрдэмтэн Дорнотив, Монголын эрдэмтэн Х.Пэрлээ, Ц.Насанбалжир, С.Жалан-аажав... зэрэг судлаачдын туурвисан бүтээл нь тухайн үеийн шинжлэх ухааны хүрсэн түвшин, шаардлагад нийцүүлэн хууль цаазын эх сурвалжийг судалсан боловч өнөөгийн эх бичиг судлалын онол, арга зүйн шаардлагад нийцэхгүй байна.

Гэхдээ судлаачдын бүтээлд эх бичгийн судлалд зайлшгүй байвал зохих галиг, орчуулга, судалгаа, тайлбар, үгийн хэлхээ зэргийн аль нэгийг эсвэл хэд хэдэн асуудлыг хамтатган авч үзсэн нь тухайн үеийнхээ хэрэгцээ шаардлагыг ямар нэгэн хэмжээгээр хангасан, мөн эрх зүйн эх сурвалжийг уг эхээр нь судлаачдад хүргэх гэсэн анхны оролдлогууд байсан.

Сүүлийн үед хууль цаазын эх сурвалжийг эрх зүйн болон эх бичгийн судалгааны орчин үеийн онол арга, арга зүйд тулгуурласан судалгаа, хөрвүүлэг, галиг, тайлбар, үгийн хэлхээ, хууль цаазын бусад эх сурвалжтай харьцуулан судлах зэрэг нэгдмэл судалгаа үгүйлэгдэж байна. Энэ талаар хууль зүйн ухааны доктор Б.Баярсайханы бүтээлүүдийг эс тооцвол эл салбар шинжлэх ухааны хүрээнд дагнан туурвисан бүтээл хангалтгүй байна.

Энэхүү өгүүлэлд 1640 оны “Их цааз”-ын уг эх, нэрийн тухай, зохиогч буюу баталсан хүмүүс, он цаг, газар орон, ашигласан эх сурвалж зэрэг эх бичиг судлалын хүрээнд зайлшгүй тодруулбал зохих асуудлыг авч үзсэн болно.

“Их цааз”-ын уг эхийн тухайд

“Их цааз”-ын анхны эхийг уйгаржин монгол бичгээр бичсэн гэж илэнхи эрдэмтэд санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг¹. Судлаачдын ийнхүү дүгнэсэн нь тод бичиг зохиогдсон он цагтай шууд холбоотой.

¹ Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”.

Судлаачид "...цааз гарснаас хойш 8 жилийн дараа буюу 1648 онд Намхайжамц тод үсэг зохиосон учраас тод үсгээр анхлан бичигдээгүй нь тодорхой², ...хуулийг 1648 он хүртэл өөрөөр хэлбэл, Зая бандид ойрад (тод) бичиг зохиох хүртэл Монголын бүх овог аймгуудын нийтлэг хэрэглээнд байсан монгол хэл болон монгол бичгээр эхэлж бичсэн. Түүнээс хойш Монгол хэлээр бичсэн эх бичгийг Ойрад бичигт хөрвүүлсэн. Тиймээс халимаг эх сурвалжид Монгол үг хэллэг тохиолддог...³, ...тэр "Их цааз" тод үсэг зохиохоос 8-9 жилийн өмнө батлагдсанаар бодвол, түүнийг монгол үсгээр анх бичсэн байх ёстой...⁴ гэх мэтээр өгүүлжээ.

Их цаазын анхны уйгаржин монгол эхийг Манжийн хааны зарлигаар бүгдийг шатаасан бололтой⁵ гэж академич Ч.Далай абугай таамаглал дэвшүүлсэн. Гэхдээ Халимагийн хан Хо өрлөг⁶ чуулганд оролцоод нутаг буцахдаа анхны эхийн нэгэн хувийг өөрийн нутагт аваачсан тухай мэдээ "Торгууд хаадын тууж"⁷-д тодорхой өгүүлсэн байна. Түүнийг дор сийрүүлбэл,

Тийн төмөр луу жил (1640)-д Дөчин, Дөрвөн хоёр хуучин эвдрэлээ уураад (болиод) санаа нь нэгдээж, шакъяагийн тойн эцэг Инцэн Ренбүчи хийгээд асах бие Манзушир, Намух Манзушир хутагт гэгээний өмнө Эрдэнэ засагт хаан, Түшээт хаан, Гүүш номын хан, Эрдэнэбаатар хунтайж тэргүүлэн хаад ноёд цугларч "Их цааз" тогтоогоод, Хо өрлөг морилж тэр баясгалант их үйлийг бүтээхэд байлцаад, тогтоосон цаазыг нутагтаа авч ирж албат нараа түүнээр баривай.

гэснээс үзвэл "Их цааз"-ын монгол эхийн нэгэн хувийг Халимагийн ард түмэн хадгалж, харин уг эх хожим тод үсгээр хуулбарлан бичсэнээр бидний үед уламжлан ирсэн.

Их цаазын Халимагт хадгалан үлдсэн монгол эх олддоогүй ч хэн нэгэн хадгалж буй гэдэгт итгэнэ. Тухайн түүхэн цаг үеийн нөхцөл байдал, нүүдлийн хэв ёсны онцлогоос хамааран олон арван оюуны үнэт бүтээлүүд гээгдэн, устаж байсны нэгэн адил хувь заяа "Их цааз"-ыг тойрсонгүй.

Харин "Их цааз"-ын тод үсгийн хувилбар эх Оросын түүхийн төв архивын халимагийн фондод нэг, ОХУ-ын ШУА-ын Дорно дахины хүрээлэнгийн Санкт-петербургийн салбарын номын санд 2, Санкт-петербургийн УИС-ийн номын санд нэг, Өвөрмонголын Нийгмийн Шинжлэх Ухааны номын санд нэг, нийт 5 эх хадгалагдаж буй⁸ мэдээ байна. Дээр дурдсан

Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 12; БНМАУ-ын түүх. Гурван боть, Дэд боть 1604-1917. УБ., 1968. 74 дэх тал; Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006. 80 дахь тал; Алтангэрэл Т. Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь. УБ., 2001. 18 дахь тал; Oyirad čayaja. Dorunativ qaridaγulun tayilburilaba. Kökeqota., 1986. 2 дахь тал гэх мэт

² Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006. 80 дахь тал

³ Голстунскаго К.Ф. "Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжскихъ калмыковъ при калмыцкомъ хань Дондукъ-Даши". Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 12-13

⁴ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. 3 боть, Дэд боть (1604-1917). УБ., 1968. 11 дэх тал; Монгол улсын түүх. 5 боть, Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн). УБ., 2003. 10 дахь тал

⁵ Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006. 81 дэх тал

⁶ Хо өрлөг нь Торгуудын ноён Зулзаган өрлөгийн хүү бөгөөд XVI-XVII зууны зааг үед торгуудыг захирч байсан төр шашны нэрт зүтгэлтэн хүн. Тэрбээр 1640 оны "Их цааз"-ыг хэлэлцэн батлах их чуулганд оролцож, тогтоосон цаазыг нутагтаа аваачин, хэрэгжүүлж байв.

⁷ Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд I. Эмхтгэж, тод болон худам монгол бичгээс кирилл бичигт буулган, тайлбар хийсэн На.Сүхбаатар. УБ., 2001. 207-208 дахь тал

⁸ Сүхбаатар На. Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд. УБ., 2006. 150 дахь тал

Санкт-петербургийн гэх гурван эх бичгийн талаар Оросын эрдэмтэн Л.С.Пучковский⁹ бүтээлдээ товч боловч тоймтой мэдээлсэн. Тэрчлэн БНХАУ-ын Өвөрмонголд “Их цааз”-ын хуулбар эх хэд хэд байна. Тухайлбал, “Ойрад цааз” болон “Галдан хунтайжийн нэгдүгээр захиа зарлиг”-ийн уг эхийг 1956 онд Өвөрмонголын Багшийн дээд сургуулиас гаргасан тод үсгийн “Ойрад түүхийн материалын эмхтгэл”¹⁰-д нийтэлсэн. Мөн Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд Мэргэнбаатарын тавиад оны үед монголчилсон “Монгол Ойрадын их цааз”, Өвөрмонголын Шилийн голын Дамираны 1962 онд монголчилсон “Монгол Ойрадын хууль цааз” гэсэн гар бичмэлийг Өвөрмонголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан, Өвөрмонголын Багшийн их сургуулийн номын санд тус тус хадгалж байна.

1950-аад оны үед Бээжингийн номын санд буй тод эхийг Мэргэнбаатар монгол бичгээр буулгасан байна. Тэрхүү хуулбар нь 35.2046. 14/1 гэсэн дугаартай, нийт 44 нүүр, 265x180 мм хэмжээтэй, төмөр хадаасан үдмэлтэй, гадар нүүрэнд “1640 он, Ойрад Зүүнгар Ховогсайр Улаан бэлчээрт. Уг зохиол тод үсгийн материал Бээжингийн улсын номын санд буй” гэсэн Мэргэнбаатарын өөрийнх нь бичсэн тайлбартай. Тэрбээр энэхүү хуулбараа 1974 онд дахин харгуулан нягталсан. Шинэ цагийн цаасан дээр 13-15 мөрөөр нэлээд замбараагүй бичсэн, урагдаж гэмтсэн байна. Арын хуудсанд Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан гэсэн монгол бичгээр бичсэн тамга, түүний дор 1101059 дугаар бүхий хөх өнгийн дардас дарсан байна¹¹.

Дамираны сийрүүлсэн үсэн бийрийн бичмэл дэвтрийн нэр нь “Монгол Ойрадын хууль цааз”, 1962 онд Мэргэнбаатарын сийрүүлэлийг шинээр сийрүүлсэн байжээ. Нийт 50 нүүр, 24,5x26,5 см хэмжээтэй¹².

БНХАУ-ын Өвөрмонголд байгаа гэх дээр дурдсан эхүүд нь ОХУ-д хадгалж буй К.Ф.Голстунский, С.Д.Дылыков нарын бүтээлд тус тус хэвлэсэн “Их цааз”-ын тод монгол эхээс хуулбарласан болох нь тодорхой.

Мөн “Ойрад цааз”-ын худам эхийн нэгэн дэвтэр Монгол Улсын Шинжлэх Ухааны дээд боловсролын зөвлөл (Шинжлэх ухааны академийг хэлсэн бололтой)-ийн номын сангийн гар бичмэлийн хөмрөгт хадгалагдаж буй гэдэг сураг зангитай боловч тэр нь эрдэм шинжилгээнийхэнд ашиглагдаагүй тул чухам ямар байдалтай эх болохыг мэдэхүйеэ бэрх байна хэмээн эрдэмтэн Ц.Бат бүтээлдээ тэмдэглэсэн байна¹³.

“Их цааз”-ын нэрийн тухайд

Их цаазын нэрийн тухай судлаачид харилцан адилгүй авч үздэг. Тухайлбал, П.С.Паллас, К.Ф.Голстунский, Ф.И.Леонтович, В.А.Рязановский... нарын судлаачид “1640 оны

⁹ Пучковский Л.С. Монгольские рукописи и ксилографы института востоковедения. Москва-Ленинград., 1957. стр 263-265

¹⁰ Улаан М. Арван долдугаар зууны ойрад түүхийн судлал. Шинжааны ардын хэвлэлийн хороо. Үрэмч., 1999. 28 дахь тал. (тод бичгээр)

¹¹ БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орон. Хөххот. Өвөрмонголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн. 2005 оны 6 сарын 27. Доктор Б.Баярсайханы хувийн тэмдэглэлээс.

¹² Batu Ć. Mongyol-Oyirad-un ĉayaja-yin biĉig-ün üge kelelge-yin sudulul. ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 2006. 45 daki tal

¹³ Batu Ć. Mongyol-Oyirad-un ĉayaja-yin biĉig-ün üge kelelge-yin sudulul. ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 2006. 19 deki tal

Монгол-Ойрадын Их цааз” хэмээн нэр оноон өгсөн. Энэхүү нэрийг хүлээн зөвшөөж буйгаа доктор Т.Алтангэрэл өөрийн бүтээлдээ тэмдэглэжээ.

Өвөрмонголын эрдэмтэн Буянөлзий, Боу Гэ нар ...тус бичгийг хүмүүс “Их цаазын бичиг”, Ойрадын их цааз”, “Ойрад монголын цааз”, “Ойрад монголын хууль цааз”, Ойрадын цааз”, “Их цааз”, “Ойрад цааз”, “Цаазын бичиг (буюу цааз бичиг), “Ойрадын их засаг”, “1640 оны Халх Ойрадын их цааз”, “Дөчин дөрвөн хоёрын их цааз”, “Монгол-Ойрадын цааз бичиг”, “Монгол, Ойрадын цаазын бичиг” гэх мэтээр адил бусаар нэрлэж байснаас бид “Монгол-Ойрадын цааз бичиг” гэдэг нэрийдлийг авав. Үнэндээ, тэдгээр олонхи товчилсон нэрийдлээс Монгол-Ойрадын цаазын бичгийг зааж байгаа гэдгийг мэдэж болох боловч зарим нэрийдэл, тухайлбал “Их цаазын бичиг” (“Баатар увш түмний түүх”-д) гэхэд эндүүрэл үүсч мэднэ. Учир нь “Монгол-Ойрадын цааз бичиг”-ийг тогтоохоос өмнө 1617 онд зүүн баруун монгол болон төвдийн шарын шашны хутагт хувилгаадын хамтарч тогтоосон “Их цаазын бичиг” гэж байсан юм. Ингэхлээр “Монгол-Ойрадын бичиг”-ийг “Их цаазын бичиг” гэж нэрлэх нь зохисгүй аж. Ийнхүү түүхийн үнэн байдалд тохируулан “Монгол-Ойрадын цаазын бичиг” гэх бүхэл нэрээр нэрийдэх нь зүйтэй¹⁴ хэмээн түүхэн талаас нь тайлбарлан нэрлэжээ. Судлаач Ц.Бат “Их цааз”-ыг Буянөлзий, Боу Гэ нарын нэгэн адил “Монгол-Ойрадын цаазын бичиг” гэж нэрлэх нь зүйтэй гэжээ.

Харин Өвөрмонголын судлаач Дорнотив бүтээлээ “Ойрад цааз” хэмээн нэрлэсэн боловч уг нэрийн талаар хэрхэн, яагаад ингэж нэрлэх болсноо тодорхой дурдсангүй.

Академич Ч.Далай ...тод үсгээр уламжлагдаж ирсэн эх зохиол нь “Ойрад монголын цааз” гэдэг нэртэй билээ. Харин “Халх, Ойрадын цааз” гэдэг нэр нь байхгүй болжээ. Үүний учир гэвэл: Нэгд, Халх, Ойрадын ноёд хамтран цааз баталсны дараа төдөлгүй Халхын ноёд цаазын агуулгыг зөрчиж, Түшээт ханы ширээнд Гомбодоржийн хөвгүүн Чахундорж (1655-1699) сууснаас хойш Монгол, Ойрадын цаазын зорилтыг зөрчих нь улам их болжээ. Тэр ч байтугай 1691 онд Манжид дагаар орсон. Иймээс Ойрадын ноёд тод монголоор буулгахдаа “Монгол Ойрадын цааз” гэдгийг “Ойрад Монголын цааз” болгон өөрчилжээ. Хоёрт, “Монгол, Ойрадын цааз” нэртэй анхны уйгаржин монгол эхийг Манжийн хааны зарлигаар бүгдийг шатаасан бололтой гэжээ¹⁵.

Оросын эрдэмтэн С.Д.Дыльков болон доктор Б.Баярсайхан, На.Сүхбаатар нар сурвалжийн мэдээг гол болгон “Их цааз” хэмээн нэрлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлжээ. Мөн На.Сүхбаатар “Халимаг хаадуудын туужийг хурааж бичсэн товч орцив” зохиолд

“...Эртний дөч, дөрөв хоёрын Их цааз монгол ба ойрадын аж суухад маш зохистой”

гэсэн тэмдэглэлд “Дөч, дөрөв хоёрын Их цааз” хэмээн тодорхой нэрлэснийг анхаарч үзэх хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлсэн¹⁶.

К.Ф.Голстунскийн хуулж хэвлүүлсэн болон С.Д.Дыльковын гэрэл зургаар буулгасан “Их цааз”-ын хоёр хувилбар эхийн оршил хэсэгт

erdeni zasaqtu xān ekilen tūšētū xān, ubaši dalai noyon, dalai xung, xung noyon, čečen noyon, dayičing xung tayiji, yeldeng noyon, mergen noyon, erdeni xung tayiji, dayibung

¹⁴ Mongyol-Oyirad-un čaγaja-yin bičig. E.Buyanöljei, Bou Ge nar qaričayulun tayilburilaba. Kökeqota., 2000. 4 deki tal

¹⁵ Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006. 80-81 дэх тал

¹⁶ Сүхбаатар На. Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд. УБ., 2006. 149 дэх тал

*xung tayiji, tenggeri toyin, ayousi xatun batur, erdeni batur xung tayiji, köndölöng ubuši, güüši nomiyin xān, örlöq, šükür dayičing, yeldeng, dayičing xošuuči, očirtu tayiji, mergen dayičing, čöüker, čečen tayiji, medēči tayiši, bo yeldeng, mergen noyon, damarin, döčün dörbön xoyoriyin noyod yeke čāji ekilen bičibe*¹⁷

хэмээн хоёуланд нь адил тэмдэглэсэн байдаг.

Миний бие ...эх сурвалж дахь “Их цааз” гэсэн нэрээр нь хэрэглэж, харин түүнийг хууль цаазын бусад эх сурвалжуудаас ялгах зорилгоор 1640 оны гэж тодотгох нь зүйтэй гэсэн доктор Б.Баярсайханы саналыг хүлээн зөвшөөж, 1640 оны “Их цааз” хэмээн нэрлэх нь бүрэн үндэстэй гэж үзэв.

Дээр дурдсан “Торгууд хаадын тууж”-д буй “... Эрдэнэ засагт хаан, Түшээт хаан, Гүүш номын хан, Эрдэнэбаатар хунтайж тэргүүлэн хаад ноёд цугларч “Их цааз” тогтоогоод, Хо өрлөг морилж тэр баясгалант их үйлийг бүтээхэд байлцаад...” гэсэн өгүүлэмж нь бидний саналыг дэмжих бас нэгэн баримт болно.

“Их цааз”-ыг 1640 оны хэмээн тодотгохдоо уг огноог цааз зохиогдсон он цагийг хэмжүүр болгон тодотгох бус, харин 1640 онд чуулган чуулсан гэдэг утгаар нь тодотгон авч үзэх нь зүйтэй.

Дондогдашийн нөхвөр хуульд ...*yosočilan bütēqči toyini ken kümün buzardan dayiran nalibāsu döčün dörböni yeke bičigēr bolyo.*¹⁸ гэсэн заалт буй бөгөөд энэхүү заалт дахь нэрийг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

“Их цааз”-ын зохиогчийн тухайд

Энэ цаазыг анх хэн, хэзээ бичсэн, түүнийг чуулган хуралдуулахаас өмнө хянан найруулсан уу, эсвэл тухайн чуулган дээр хэлэлцэж баталсан уу гэдгийг цаазад дурдаагүй¹⁹.

Энэхүү асуудлыг судлаачид өөр өөрөөр авч үздэг. Оросын эрдэмтэн В.А.Рязановский ...Монгол-Ойрадын хуулийг зохиосон байж болох Баатар хунтайж, уг хуульд оруулсан нэмэлтийн жинхэнэ зохиогч Баатар хунтайжийн хүү Галдан нар...²⁰ гэснээс үзвэл “Их цааз”-ын анхны эхийг Баатар хунтайж боловсруулсан гэсэн таамаг, харин Галдан хунтайжийн захиа зарлигийн жинхэнэ зохиогч нь Галдан мөн гэж үзсэнийг тодорхой мэдэж болохоор байна.

¹⁷ Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. Эрхлэн хэвлүүлсэн Н.Лүндэндорж, Б.Баярсайхан. УБ., 2004. 40 дэх тал, Дылыков С.Д. “Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в. Ойратский текст. Транслитерация сводного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарий. М., 1981. Стр 124-125

¹⁸ Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. Эрхлэн хэвлүүлсэн Н.Лүндэндорж, Б.Баярсайхан. УБ., 2004. 62 дахь тал

¹⁹ Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 8

²⁰ Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын түүхэн тойм, Их засаг хууль. УБ., 2000. Орчуулсан Ч.Баатар, Н.Лүндэндорж. 19 дэх тал

Харин К.Ф.Голстунский ...Янз бүрийн мэдээ баримтаас үзэхэд тухайн цаазын урьдчилсан найруулга нь чуулганаас өмнө 1635 онд бичигдсэн. Харин чуулганаар тухайн хуулийг бүхэлд нь эцэслэн боловсруулж баталсан. Яагаад гэвэл, уг цаазад Монгол Ойрадын ноёдын хамтран хэлэлцэж батлах ёстой зүйлүүд байсан. Хэрэв цаазыг урьдчилан найруулж бичсэн гэж үзвэл, түүний зохиогч нь хэн бэ гэсэн асуулт гарч ирнэ. Зарим түүхэнд Баатар хунтайж бичсэн гэдэг боловч үүнд үндэслэл болох нэг ч баримт байдаггүй. Харин чуулганаар баталсныг цаазад тодорхой бичсэн. Хэрэв тухайн цаазыг чуулганаас өмнө бичсэн гэж үзвэл тухайн үеийн байдлаас шалтгаалан түүнийг Баатар хунтайж зохиосон гэж үзэж болно..., ...цаазын уг эхээс харахад тэдгээрийг зохиоход Баатар хунтайжийн нөлөө байгаа нь уг хуульд түүний болон Ойрадын ашиг сонирхол давамгайлснаар харагдаж байна. Жишээлбэл, Баатар хунтайжийн төрсөн дүү нар болох Дайчин, Цөхүр зэрэг ноёдыг бусад ноёдоос дээгүүр зэрэгт тавьсан, Баатар хунтайжийн өвөг эцэг Була тайшийн урьдын өрийг хүчингүй болгосон, хагаралын үед Ойрадад ирсэн Халх монголчууд Ойрадын харьяанд үлдэх ёстой, харин Ойрадаас явсан хүмүүсийг Ойрадад буцаах ёстой байсан гэх зэргээр дурдаад хэрэв ноёдын чуулган Баатар хунтайжийн ашиг сонирхлын дагуу явагдсан бол, хэрэв түүний нөлөө хууль батлахад илт харагдаж байгаа бол Монгол Ойрадын хувьд улс төрийн харилцан ашигтай зүйлүүдийг эс тооцвол уг хуулийг тухайн ноёдын чуулганд зориулан Баатар хунтайж бэлтгэн бичсэн гэсэн үг юм. Баатар хунтайж уг цаазын зохиогч, харин чуулганы үүрэг зөвхөн батлах явдалаар хязгаарлагдсан гэсэн шууд баримт бас бидэнд байхгүй байна гэжээ²¹.

Мөн Оросын эрдэмтэн И.Я.Златкин уг цаазын эх нооргийг зохиож, чуулганыг зарлан хуралдуулагч нь Зүүнгарын хан Баатар хунтайж мөн бололтой гээд чуулганыг Халх, Хөхнуур, Ижил мөрөнд бус, Зүүнгарын нутагт хийсэн явдал нь Баатар хунтайжийн санаачилсан болохыг давхар нотолно хэмээн бичсэн байдаг²².

Нягтлан үзэхүл, энэ мэт санал бодолыг дараа дараагийн судлаачид дагаж бичсэн нь ажиглагдаж байна.

Ер нь аль нэг сурвалжийн зохиогчийг тодруулахад зөвхөн таамаг төдий бүдэг баримтаар эш үндэс хийж, түүнийгээ түүхийн үнэн болгон тайлбарлах нь уг асуудлыг эцэслэн шийдэх бодот үнэнд хүрч буйн илэрхийлэл гэж үзэхгүй байна. Үүний учир, юун түрүүнд тэрхүү сурвалжийн хэл найруулга, үгийн сангийн онцлог, тулгуурласан эх сурвалж хэрэглэгдэхүүн, түүхэн үйл явдал зэрэг олон хүчин зүйлийг тал бүрээс нь хянан магадлавал зохино²³.

“Их цааз” нь Ёүтэцийн хувьд

- 1640 оны “Их цааз”

- 1676-1678 он хүртэл хугацаанд тогтоосон Ойрадын Галдан Хунтайжийн захиа зарлиг

- 1741-1761 оны хооронд Торгуудын ноён Дондогдашийн оруулсан нэмэлт нөхвөр гэсэн үндсэн хэсгээс бүтдэг. Өөрөөр хэлбэл, хууль цаазын эмхтгэл гэж дүгнэх бүрэн үндэстэй.

Мөн “Их цааз” болон нэмэлтүүдийн бичигдсэн хэл, агуулга ч тус тус өөр өөрийн онцлогтой байна. Тухайлбал, 1640 оны “Их цааз”-ын үндсэн эх нь Зая бандидын зохиосон тод

²¹ Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжскихъ калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 8-10

²² Златкин И.Я. История Джунгарского ханства. Москва., 1964. стр 176-177. дам эшлэв

²³ Хаадын үндсэн хураангуй алтан товч. “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” 6-р боть. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006. 5 дахь тал

үсэг²⁴-ийн хэлээр бичигдсэн байхад Дондогдашийн нөхвөр цааз Зая бандидын зохиосон цагаан толгойн үсгийг дахин тодорхой болгож өөрийн аялгуунаа тохируулсан Халимагийн тод үсгийн хэлээр бичигдсэн байна.

“Их цааз”-ын агуулгыг судлаачид янз бүрээр авч үздэг. Агуулгын хувьд “Их цааз”-ын үндсэн эх нь дотоод засаг төрийн тухай, гадаад дайсан, улаа ба элчийн тухай, шашин шүтлэг, онц эрхийн тухай, гөрөөчлөх тухай, зан суртахуун, хүн алсан, өмч асрамжийн тухай, худ ураг, зэвсэг үйлдэх тухай, хулгайч гүжирчийн тухай, асарсан хөвгүүд, охидын тухай, оргуул босгуулын тухай, галзуу нохой, галзуу хүний тухай, бусдын малыг алсан тухай, түймэр, усны аюулын тухай, өр авлагын тухай, жилийж завхарсан малын тухай, ужид самуун байдлын тухай, хэрүүл, хараалын тухай, мал алах, аврахын тухай, хүн аварсан, булаасан тухай, бэдрээ, гэрчийн тухай, нэгжүүлийн тухай, зудад үхсэн малын тухай, малын сүү саах тухай гэсэн нийгмийн бүх хүрээний асуудлыг шийдвэрлэж өгсөн бүлэг заалтууд тусгагдсан бол Галдан хунтайжийн нэгдүгээр захиа зарлигт отог байгуулах, засаг захиргааны шинэчлэлээ хуульчлан баталгаажуулах зэрэг дотоод засаглалын тухай, хулгайчийн тухай, бэдрээгийн тухай, өр авлагын тухай, завхарсан малын тухай; хоёр дахь нэмэлт нь бэдрээгийн тухай, Хотонтой хэрхэн харьцах тухай гэсэн төрлүүдээс бүрдэж байна.

Мөн Дондогдашийн нөхвөр цааз нь “Их цааз”-ын зарим зүйлийг нэмэн баяжуулсан шинжтэй ба энэ нь шашин суртахууны тухай, сургууль боловсролын тухай, гадаад дайсны тухай, онц эрх, бэдрээгийн тухай, хулгайчийн тухай, дотоод засаг төрийн тухай, улаа элчийн тухай, шахааны тухай, өр авлага, гэрчийн тухай, булаан дээрэмдэлт, морь хулгайлсан хэргийн тухай, оргуул босгуулын тухай, мал аврах тухай, зан заншлын тухай, завхарсан малын тухай, гөрөөчлөх тухай зэрэг тухайн үеийн нийгмийн амьдралын шаардлагаар залруулж баяжуулсан онцлогтой.

Нэмэн өгүүлэхэд, монголчууд эртнээс нааш Чингисийн “Их засаг”, Хубилай хааны зарлигаар тогтоосон “Арван буянт номын цагаан түүх”, “Хутагтай сэцэн хунтайжийн шашны цааз”, “Алтан ханы цаазын бичиг”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, 1640 оны “Их цааз”, “Халх журам”... зэрэг их бага цаазыг удаа дараа боловсруулан, мөрдөж ирсэн түүхтэй ч тэдгээр цаазыг хэний зарлигаар боловсруулсан буюу зохиосныг дурьдсан нь цөөхөн байна.

Зарим цаазын бичигт тухайлбал, “Бичин жилийн их цааз”-д ...дээд тэнгэр бурхны заяагаар төрсөн, тэнгэрлэг төрөлт, төгс эрдэм билгийн залгамж болсон Алтаны ураг хаан ахай, засаг барьсан Хатанбаатар ноён, засаг барьсан дархан түшээт ноён, Дайчин баатар ноён, Хөндлөн цүүхэр ноён, Зоргол ноён, Хошууч ноён, Зоригт ноён, Цогт ноён, Хулан авай ноён, Илдэн ноён хошууч ноён, Бинт ноён, Убандай ноён, Өлзийт ноён, Мэргэн тайж, Сэцэн тайж, Хун тайж, Дайчин тайж, Цогт тайж, Рахул тайж, их бага ноёдоос тэргүүлэн их цааз эхлэн бичив²⁵, бидний судлагдахуун болох “Их цааз”-д ...Эрдэнэ засагт хан эхлэн Түшээт хан, Убаши далай ноён, Далай хун, Хун ноён, Цэцэн ноён, Дайчин хунтайж, Илдэн ноён, Мэргэн ноён, Эрдэнэ хун тайж, Дайбун хун тайж, Тэнгэр тойн, Аюуш хатан баатар, Эрдэнэ баатар хунтайж, Хөндлөн убаши, Гүүш номын хан, Өрлөг, Шүхэр дайчин, Илдэн, Дайчин хошууч, Очирт тайж, Мэргэн дайчин, Цөүхэр, Цэцэн тайж, Мэдээч тайш, Бөө Илдэн, Мэргэн ноён, Дамиран, дөчин

²⁴ Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975

²⁵ Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). I дэвтэр, Эмхтгэсэн Б.Баярсайхан, УБ., 2006. 33 дахь тал

дөрвөн хоёрын ноёд их цааз эхлэн бичив²⁶ гэх зэргээр өгүүлсэн нь эдгээр ноёд цаазын бичгийг зохиосон бус харин чуулган хуралдуулж, цаазыг хэлэлцэн батлагсад юм.

Ер нь ХҮИ-ХИХ зууны үед холбогдох монголын хууль цаазын эх сурвалжуудыг тус бүр анх хэн боловсруулсан тухай мэдээ баримт бараг байдаггүй бөгөөд харин зарим тохиолдолд орон нутгийн шинжтэй зарим нэгэн цаазад тухайн хошуу захирагчийн нэрээр тодотгон эрх бүхий этгээдүүд хэлэлцэж тогтоосныг хууль цаазын эх сурвалжид дурдсан байдаг. Тухайлбал, ...Тэнгэрийн тэтгэсний аравдугаар он, хаврын сүүл сарын арван долоон өдөр. **Хотогойдын туслагч увш Цогт ахайтай** хэлэлцсэн цааз²⁷ ... гэх мэт.

“Их цааз”-ыг батлахад оролцсон ноёдын нэр, цол болон хэд хэчнээн ноёд оролцсон тухай асуудал нэгэн мөр шийдэгдээгүй бөгөөд “Их цааз”-ыг хэлэлцэхэд хэд хичнээн хүн оролцсон талаар нийт 27, 28, 29, 30, 32 гэх зэргээр өөр өөрөөр тэмдэглэсэн бөгөөд тэдгээр хүмүүсийн нэрийг хооронд нь хольж хутгах, нийлүүлж салгах зэргээр янз бүрээр авч үзсэн байна.

Энэ бүхнийг үл нуршин хоёр хувилбар эхийн тухайн хэсгийг харьцуулж үзүүлбэл²⁸,

erdeni zasaqtu xān ekilen tūšētü xān, ubaši dalai noyon, dalai xung, xung erdeni zasaqtu xan ekilen tūšētü xān, ubaši dalai noyon, dalai xūng, xūng noyon, čēčen noyon, dayičing xung tayiji, yeldeng noyon, mergen noyon, noyon, čēčen noyon, dayičang xong tayiji, yeldeng noyon, mergen noyon, erdeni xung tayiji, dayibung xung tayiji, tenggeri toyin, ayoüsi xatun bātur, erdeni xong tayiji, dayibung xong tayiji, tenggeri toyin, ayoüsi xatun bātur, erdeni bātur xung tayiji, köndölöng ubaši, güüši nomiyin xān, örlöq, šükür erdeni bātur xong tayiji, köndölöng ubaši, güyiši nomiyin xān, örlöq, šüker dayičing, yeldeng, dayičing xošouči, očirtu tayiji, mergen dayičing, čöüker, dayičang, yeldeng dayičing xošouči, očirtu tayiji, mergen dayičing, čöüker čēčen tayiji, medēči tayiši, bu yeldeng, mergen noyon, damarin, döčin čēčen tayiji, medēči, tayišui, bu yeldeng, mergen noyon, damarin, döčin dörbön xoyoriyin noyod yeke čāji ekilen bičibe.
*dörbün, xoyoriyin noyod yeke čāji ekilen bičibe.*²⁹

Зөвхөн дээр нэр дурдагдсан эдгээр ноёд цааз хэлэлцэн батлахад оролцсон бус, харин тухайн үеийн нөлөө бүхий ноёдын нэрсийг цаазад бичсэн болов уу гэж үзэж байна.

Судлаачид цаазын эхэнд нэр дурдагдсан төвдийн шарын шашны хутагт хувилгаадыг цаазад оролцсон эсэх талаар нэгдсэн саналд хүрээгүй.

²⁶ Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). I дэвтэр, Эмхтгэсэн Б.Баярсайхан, УБ., 2006. 38 дахь тал

Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). I дэвтэр, Эмхтгэсэн Б.Баярсайхан, УБ., 2006. 38 дахь тал

²⁸ “bold” /тод/ шриффтээр К.Ф.Голстунскийн үсэг өрж хийсэн тод үсгийн эхийн хэсгийг, “italic” /налуу/ шриффтээр С.Д.Дылыковын гэрэл зургаар буулгасан сударын эхийн хэсгийг тэмдэглэв

²⁹ Голстунскаге К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыков при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаниями. СПб., 1880. Эрхлэн хэвлүүлсэн Н.Лүндэндорж, Б.Баярсайхан. УБ., 2004. 40 дэх тал, Дылыков С.Д. “Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в. Ойратский текст. Транслитерация сводного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарий. М., 1981. Стр 124-125

К.Ф.Голстунский Зая Бандидыг чуулганд оролцсон гэжээ. Үнэхээр ч дээрх чуулганд оролцсон болов уу гэдэг үндэс бас байна. 1639 оны намар Төвдөөс ирмэгцээ Тарвагатайд, Очирт тайжийнд өвөлжөөд 1640 оны чуулганд Баатар хунтайж зэрэг Ойрадын бусад дээдэстэй эн зэрэгцэх байранд Зая Бандид байсан учраас л түүний нэр нь Халхын ноёдод алдаршиж 1641 оны хавар Халхын Засагт хан элч илгээн Зая Бандидыг урихад хүрсэн байж болохоор байна. Хэрэв 1640 оны чуулганд Зая Бандид оролцоогүй байсан бол Халх нутгаас зайлуу Тарвагатайд, Очирт тайжийнд, Төвдөөс ирж өвөлжсөн нэгэн залуу ламыг Халхын ноёд яахин мэдэх билээ³⁰.

Тэрчлэн дээрхи харьцуулгаас үзэхүл, К.Ф.Голстунскийн эхэд Илдэн, Дайчин хошууч, Цөүхэр, Цэцэн тайж гэсэн дөрвөн хүний нэрээр тэмдэглэсэн байхад С.Д.Дыльковын эхэд Илдэн дайчин хошууч, Цөүхэр цэцэн тайж хэмээн хоёр хүн мэтээр, мөн Өвөрмонголын эрдэмтэн Дорнотив Мэргэн ноён, Дамиран гэх хоёр хүнийг Мэргэн ноён Дамиран гэж нэг хүн мэтээр ойлгон, тэрхүү ойлголтоороо тайлбарласан байх жишээтэй.

Энэ бүхнийг түүхийн үүднээс хянан магадалбал зохих ба дэлгэрүүлэн үзнэ гэх ахул энэ талаар Ц.Цэрэндорж нар тун саяхан сонирхолтой өгүүлэл нийтлүүлсэн бөлгөө³¹.

“Их цааз”-ыг баталсан он цагийн тухайд

“Их цааз”-ын эхэд ...баатар төмөр луу хэмээх жилийн намрын дундад сарын таван шинэд сайн өдөрт... хэмээн тодорхой заажээ. Энэ нь нийтийн он тоололын 1640 он болно.

Гэвч уг цаазын бүтэцийг “Их цааз”-ын үндсэн эх, Галдан хунтайжийн хоёр удаагийн нэмэлт болон Дондогдашийн нөхвөр хууль гэсэн хэдэн хэсгээс бүтдэг гэж үзвэл уг цаазыг хэлэлцэн баталсан анхны он 1640 болохоос эцэслэн боловсруулж дууссан он цаг гэж үзэх нь эргэлзээтэй.

Харин дотор нь задалж 1640 оны чуулганаар хэлэлцэн баталсан “Их цааз”-ын үндсэн эхийн зохиож дууссан он цагийг 1640, Галдан хунтайжийн нэгдүгээр захиа зарлигийг 1676, хоёрдугаар захиа зарлигийг 1678, Дондогдашийн нөхвөр хуулийг 1741-1761 оны хооронд зохиож дууссан гэж үзвэл зохилтой.

Галдан хунтайжийн нэгдүгээр захиа зарлигийн дотор он цагийг дурдаагүй ч түүхэн үйл явдал болон Галдан хунтайжийн Зүүнгарын хаант улсыг байгуулсантай холбон 1676 онд зохиосон гэж үздэг.

Хоёр дахь захиа зарлигт “шороо морин жилийн цагаан сарын шинийн сайн өдөр бичив” хэмээн тэмдэглэсэн нь нийтийн он тооллын 1678 он болно.

Дондогдаш хааны нөхвөр хуулийн зохиогдсон он цагийн талаар тодорхой баримт байдаггүйгээс Дондогдаш ханы үед гэх буюу 1741-1761 оны хооронд гэж бичиж тэмдэглэж ирэв³².

“Их цааз”-ыг хэлэлцэн баталсан газар орны тухайд

1640 оны “Их цааз”-ыг баглах Их чуулган болсон газрын нэрийн талаар судлаачид мөн л харилцан адилгүй авч үзжээ. Монголын болон Орос, Германы эрдэмтэд³³ их төлөв Тарвагатайн нурууны Улаан бураа хэмээх газар чуулганыг чуулсан гэдэг.

³⁰ Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975. 13-14 дэх тал

³¹ Цэрэндорж Ц. “Их цааз”-ын тогтоосон үйл явцын талаархи зарим шинэ мэдээ. МУИС-ХЗС. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 1/2007 (15). УБ., 2007. 157-163 дахь тал

³² Сүхбаатар На. Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд. УБ., 2006. 155 дахь тал

Зарим нь, тухайлбал Өвөрмонголын эрдэмтэд ...Зүүнгарын Баатар хунтайжийн нутаг бөгөөд Халх монголоос Дөрвөн Ойрадын нутагт хүрэх замын уулзвар газар болох Эрчис мөрний Мааньт гаталгааны орчимд...³⁴ гэж үзэж байна.

Мөн Халхын нутагт чуулсан³⁵, зарим нь тухайлбал, Оросын эрдэмтэн Костенков, Ровинский, Муллов нар Оросын нутагт батлагдсан³⁶ хэмээн ямар ч үндэслэл нуталгаагүй бичсэн нь ч буй.

Миний бие ихэнхи судлаачдын тэмдэглэснээр “Их цааз”-ыг бичиж дуусан, санал нэгтэй батлан хэлэлцсэн тэрхүү газрыг Тарвагатайн нурууны Улаан бураа хэмээн үзлээ.

Ингэж үзэх үндэслэл нь хэдийгээр ихэнхи судлаачдын байр суурийг баримталж буй хэдий ч эх бичиг судлалын онол, арга зүйн хувьд сурвалжийн газар орныг тогтоохдоо тухайн сурвалж дахь нутгийн аялгууны онцлог, бичвэрийн хэв маяг зэрэг хэд хэдэн зүйлийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд уг цаазад торгууд, захчин зэрэг аялгууны үг цөөнгүй тохиолдож байна. Тухайлбал, захчины аман аялгуунд “mög”-ийг “mor” гэх ба мөн тус цаазад “aqta” хэмээх үг хоёр удаа тохиолдож буй бөгөөд нэг нь “aqta ajirγa” гэж байна. Энэ нь агталсан азаргыг хэлж буй хэрэг бөгөөд Захчины аман аялгуунд, мөн буриадад агт тодотголтой үгийг ялгамжаатай тэмдэглэсэн байдаг. Үүнд:

агта мал – мал, адгуус

агта тэмээ – атан тэмээ

агта азарга – агталсан азарга

агта морин – сайн морь

агта гахай – эр гахай

агта мэгэжэ – төрүүлэхгүй, таргалуулахаар өндөгний үүрийг (уураг хоты нь) авсан охин гахай

агта нохой – агталсан нохой гэх мэт³⁷.

“Их цааз”-ын эх сурвалжийн тухайд

Хамгийн анх Оросын эрдэмтэн Ф.И.Леонтович “Их цааз”-ын эх сурвалжийг “...1640 оны хууль хоёр үндсэн эх сурвалжтай иосун буюу юсун (эртний монголын засаг хууль) овгуудын заншлын эрх, дараа нь (Иакинфагийн хэлснээр) ХҮ, ХҮІ зууны үед бүх Ойрад

³³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. 3 боть, Дэд боть (1604-1917). УБ., 1968. 74 дэх тал; Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975. 21 дэх тал; Авирмэд Э, Дашцэдэн Д, Совд Г. Монгол хууль. УБ., 1997. 59 дэх тал; Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997. 126 дахь тал; Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006. 80 дахь тал; Сүхбаатар На. Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд. УБ., 2006. 149 дэх тал; Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыковъ при калмыцком хань Дондукъ-Даши”. Калмыцкий текстъ съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 10-12; Дылыков С.Д. “Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в. Ойратский текст. Транслитерация сводного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарий. М., 1981. стр 3;... гэх мэт

³⁴ Ouyrad čaγaja. Dorunatib qaricaγulun tayilburilaba. Kökeqota., 1985. 10 daki tal; Mongyol-Ouyrad-un čaγaja-yin bičig. E.Buyanöljei, Bou Ge nar qaricaγulun tayilburilaba. Kökeqota., 2000. 6 daki tal

³⁵ Владимирцов Б.Я. Общественный строй Монголов. М., 1934. стр 21. дам эшлэв.

³⁶ Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль. Орчуулсан Ч.Баатар, Н.Лүндэндорж. УБ., 2000. 19 дэх тал

³⁷ Цолоо Ж, Рэгзэндорж Р. Монгол улсын буриад монголчууд. УБ., 2005. 25 дахь тал.

аймгуудад үйлчилж байсан арга хэмжээний дүрэм”-д багтах аймгуудын хуулиуд буюу цаазны бичгүүд өөрөөр хэлбэл Монгол Ойрадын бүх аймгуудын шинэ хууль хүртэл үйлчилж байсан бөгөөд одоо үед Халимагуудад “эртний Халимагчуудын тогтоолууд” гэдэг нэртэй хадгалагдаж байгаа хуулиуд юм”³⁸ хэмээн тодорхойлжээ.

Профессор С.В.Юшков Ф.И.Леонтовичийн санааг дэмжиж, Чингисийн Их засаг, зарлигууд, орон нутгийн хуулиуд, XV, XVI зууны үеийн монголын хуулиуд, хаадын цааз, зарлигууд, буддын шашны ёс журмууд нь “Их цааз”-ын эх сурвалж болно³⁹ гэсэн бол К.Ф.Голстунский дээрхи хоёр саналыг эс зөвшөөрөн 1640 оны Монгол ойрадын хуулийн анхны бичмэл эх сурвалжийн талаар тодорхой нааштай зүйл хэлэх боломжгүй юм. Ийм эх сурвалжийг олж тайлбарлах бүх оролдлого түүхэн ямар ч үндэслэлгүй болох бөгөөд харин таамаглал маягаар дэвшүүлж болно. Чингис хааны Их засаг, пайз, шашны эрх ч тэр 1640 оны хуулийн хувьд бичмэл эх сурвалж нь байгаагүй бөгөөд байх боломжгүй юм. Тухайн үеийнхээ үзэл санааг илэрхийлж байсан Чингис хааны Их засаг хууль нь өөрийн онцлогтой байсан бөгөөд тэдгээр нь зөвхөн тухайн үеийн нөхцөл байдал болон Чингис хааны засаглалд нийцэн гарч байсан... гээд, ...албан ёсны баримт бичиг болох пайз, зарлигийг XVII зууны Монгол ойрадууд мөн л мэдэж байгаагүй. Шашны эрх нь 1640 оны хуульд ямар ч хамааралгүй хэмээн няцааж 1640 оны Монгол ойрадын хууль нь бие даан бичигдсэн ба өөрийн гэсэн эх сурвалжтай гэж үзэх нь илүү үндэстэй юм гэжээ. Тэрбээр хуулийн бие даасан эх сурвалжийг

1. Хэв хууль ардын зан заншил

2. Тухайн үеийн Монгол Ойрадын нийгэм, улс төрийн нөхцөл байдал болон чуулган хуралдах болсон шалтгаан

3. Шашны хөдөлгөөн, Зонховын шар малгайтны урсгал дэлгэрсний үр дагавар байж болох юм гэжээ⁴⁰.

Түүрүү үеийн судлаачдын байр суурийг авч үзвэл, 1640 оны хуулийн эх сурвалж ёс заншил гэж Иакинф бичсэн бөгөөд Паллас дээр нь нэмж Цаазын бичгийг дурджээ.

В.А.Рязановский бээр Чингис хааны Засаг хууль, чингисийнхний хууль цаазууд 1640 оны хуулийн шууд эх сурвалж болж чадаагүй харин үндсэн бөгөөд хамгийн гол эх сурвалж бол монгол аймгуудын ердийн хууль цааз гарцаагүй мөн хэмээсэн байна⁴¹.

Профессор Г.Совд “Их цааз”-ын эх сурвалжийн талаархи судалгаануудыг харьцуулан шинжлээд Чингисийн Их засгийг бичмэл бус хэлбэртэй байсан гэж үзлээ ч тэр нь 1640 оны Монгол-Ойрадын хуулийн бичмэл эх сурвалж болохыг үгүйсгэхгүй. Үүнээс уламжлан Монгол цаазын бичиг, хаадын зарлиг, цааз дэвтэр зэрэг нь энэ хууль гарахаас өмнө үйлчилж байсан

³⁸ Леонтович Ф.И. К истории права русских инородцев. Древний Монгол-ойратский устав взысканий (цаазны бичиг). Одесса 1879. стр 16. дам эшлэв.

³⁹ Юшков С.В. История государство и права СССР част I. Москва, 1940. стр 405. дам эшлэв.

⁴⁰ Голстунского К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыков при калмыцком хань Дондукь-Даши”. Калмыцкий текст сь русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. стр 10-12

⁴¹ Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль. Орчуулсан Ч.Баатар, Н.Лүндэндорж. УБ., 2000. 17-18 дахь тал

хууль цаазын дурсгалт бичгүүд нь түүний эх сурвалж болсон гэж үзэх ёстой⁴² хэмээснийг Т.Алтангэрэл⁴³ нарын судлаачид дэмжиж буйгаа тэмдэглэжээ.

Энэ мэтээр судлаачид янз бүрийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байна. Энэ бүхнийг үл нурушин тэдгээр судалгааны үр дүнг нэгтгэн судалж, “Их цааз”-ын агуулга, шинж чанарыг эргэцүүлж, илүү нарийвчлан авч үзсэн доктор Н.Лүндэндоржийн саналыг хүлээн зөвшөөж, түүний “... энэ хуулийн жинхэнэ эх сурвалж бол эртний цаазын бичгүүд гэж үзэх нь илүү үнэнд дөхөх бизээ. Энэ үзлийг дэмжих үндэслэл нь хэдийгээр түүхэн үйл явц- уламжлал, шинэчлэлийг агуулдаг гэсэн онол, арга зүйн түгээмэл зарчмын үүднээс монголчуудын зан заншилд тулгуурласан эх сурвалжуудын үзэл санааны нөлөөнөөс ангид авч үзэхгүй боловч “Монгол-Ойрадын цааз”-ын үндсэн үзэл баримтлал- тухайн үеийн нийгмийн бодит байдал, үүссэн нөхцөл байдлыг тэр цагийн шударга үнэн, зүй ёсны үзлийн үүднээс үнэлж, зохицуулахыг зорьсонд оршино⁴⁴” гэж дүгнэсэнтэй санал нэг байна.

Мөн “Их цааз”-ыг зохиоход XVI зууны хоёрдугаар хагас, XVII зууны эхэн үеэр буй болсон цаазын бичгүүдийг сурвалж болгон ашигласнаас гадна эртнээс аваад монголын нийгэмд хэрэглэгдэж ирсэн зарим хэв хууль, уламжлалыг мөн ашигласан нь тодорхой⁴⁵.

Эх бичиг судлалын үүднээс эх сурвалжийг тодруулах баримт, тухайлбал: авиан зүй, хэлбэр судлал (asaqci, xulaqci, yidekule ... гэх мэт) болоод үгийн сан, утга зүйн хүрээнд (maxalai, küiken, olbu, ondosho ... гэх мэт) олон үг эртний хэв байдалаа хадгалан буй бөгөөд энэ нь дээрхи үзэл бодолыг батлах бас нэгэн баримт болно.

SUMMARY

This article deals with the urgent textological problems of the "Ikh tsaaz" (Great Law) adopted in the year of 1640, concerning its original text and the name, the authors and those who ratified it, the date and the place of compiling, the sources used in it and so on.

⁴² Совд Г. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ., 1973. 32 дахь тал.

⁴³ Алтангэрэл Т. Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь. УБ., 2001. 25 дахь тал

⁴⁴ Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 215-216 дахь тал

⁴⁵ Бира Ш. Монголын түүх соёл түүх бичлэгийн судалгаа. Токио., 1994. 82 дахь тал

Ашигласан ном зүй

1. Авирмэд Э, Дашцэдэн Д, Совд Г. Монгол хууль. УБ., 1997.
2. Алтангэрэл Т. Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь. УБ., 2001.
3. Batu С. Mongyol-Oyirad-un çayaja-yin biçig-ün üge kelelge-yin sudulul. üндүсүтен-ü keblel-ün qoriy-a, 2006.
4. Бира Ш. Монголын түүх соёл түүх бичлэгийн судалгаа. Токио., 1994.
5. БНМАУ-ын түүх. Дэд боть 1604-1917. УБ., 1968.
6. Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997.
7. Владимирцов Б.Я. Общественный строй Монголов. М., 1934.
8. Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыков при калмыцком хань Дондукь-Даши”. Калмыцкий текст съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880. Эрхлэн хэвлүүлсэн Н.Лүндэндорж, Б.Баярсайхан. УБ., 2004.
9. Голстунскаго К.Ф. “Монголо-Ойратские законы 1640 года, дополнительные указы Галдань-хунь-тайджия и законы, составленные для волжских калмыков при калмыцком хань Дондукь-Даши”. Калмыцкий текст съ русскимъ переводомъ и примечаніями. СПб., 1880.
10. Далай Ч. Ойрад монголын түүх. Тэргүүн боть, хоёр дахь хэвлэл. УБ., 2006.
11. Дыльков С.Д. “Их цааз <<Великое уложение>> Памятник монгольского феодального права XVII в. Ойратский текст. Транслитерация сводного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарий. М., 1981.
12. Златкин И.Я. История Джунгарского ханства. Москва., 1964.
13. Леонтович Ф.И. К истории права русских инородцев. Древний Монгол-ойратский устав взысканий (цаазны бичиг). Одесса 1879.
14. Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975
15. Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002.
16. Монгол улсын түүх. 5 боть, Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн). УБ., 2003.

17. Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). I дэвтэр, Эмхтгэсэн Б.Баярсайхан, УБ., 2006.
18. Mongyol-Oyirad-un šaγaja-yin bičig. E.Buyanöljei, Bou Ge nar qaricāyulun tayilburilaba. Kökeqota., 2000.
19. Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд I. Эмхтгэж, тод болон худам монгол бичгээс кирилл бичигт буулган, тайлбар хийсэн На.Сүхбаатар. УБ., 2001.
20. Oyirad šaγaja. Dogunativ qaricāyulun tayilburilaba. Kökeqota., 1986.
21. Пучковский Л.С. Монгольские рукописи и ксилографы института востоковедения. Москва-Ленинград., 1957.
22. Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын түүхэн тойм, Их засаг хууль. УБ., 2000. Орчуулсан Ч.Баатар, Н.Лүндэндорж.
23. Совд Г. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ., 1973.
24. Сүхбаатар На. Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд. УБ., 2006.
25. Улаан М. Арван долдугаар зууны ойрад түүхийн судлал. Шинжааны ардын хэвлэлийн хэроо. Үрэмч., 1999.
26. Хаадын үндсэн хураангуй алтан товч. “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” 6-р боть. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006.
27. Цолоо Ж, Рэгзэндорж Р. Монгол улсын буриад монголчууд. УБ., 2005.
28. Цэрэндорж Ц. “Их цааз”-ын тогтоосон үйл явцын талаархи зарим шинэ мэдээ. МУИС-ХЗС. “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 1/2007 (15). УБ., 2007.
29. Юшков С.В. История государство и права СССР част I. Москва, 1940.